

БАТЛАВ.
 БҮХ НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛЫН
 ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА БӨГӨӨД
 ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД



Х.НЯМБААТАР

**БҮХ НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ
 ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
 (2021 он)**

Хөтөлбөрийн зорилго: Иргэдийн эрэлт хэрэгцээг хангахуйц эрх зүйн мэдээ, мэдлэгийг цахим болон цахим бус байдлаар нээлттэй, хүртээмжтэй, энгийн хялбарчилсан хэлбэрээр хүргэх замаар бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлэх.

Эхний шатгны үйл ажиллагаанд үнэлгээ хийж, Бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх тогтолцоог бэхжүүлэхэд оршино.

№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
Зорилт 1: Бүх нийтийн эрх зүйн боловсролын агуулга, арга зүйг хүний эрхэд суурилсан хандлага, арга зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.						
Үйл ажиллагааны чиглэл 1.1. Иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангасан, зорилтот бүлэгт /тухайлбал өндөр настан, хүүхэд, харааны болон сонсголын бэрхшээлтэй иргэн/ ээлтэй, тэдгээрийн нас, сэтгэхүйн онцлог, нийтлэг болон тусгай хэрэгцээ шаардлагад тохирсон эрх зүйн боловсролын агуулгыг хүний эрхэд суурилсан хандлага арга зүйд нийцүүлэн боловсруулах						
1.1.1	Байгууллагын дотоод болон эрхлэх асуудлын хүрээнд Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн төлөвлөгөөг боловсруулан баталж, холбогдох алба хаагчид хариуцуулан хэрэгжүүлэх	Төлөвлөгөө тайлан	жилдээ	Үндэсний зөвлөл	ХЗҮХ, Холбогдох байгууллага	Төлөвлөгөөний дагуу тайланг Ажлын албанд ирүүлсэн байна.
1.1.2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эрх зүйн мэдлэг олгох сургалтыг хөтөлбөр, гарын авлагын дагуу зохион байгуулах	Сургалт	жилдээ	ХБИНХ	ХБХХЕГ, ХЗҮХ	Сургалт зохион байгуулсан байна.
1.1.3	Гэр бүлийн хүчирхийллийн гэрч, хохирогч /насанд хүрээгүй/-ийг илрүүлэх, хамгаалах, туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулж, эрхээ хамгаалах эрх зүйн мэдлэг олгох	Зөвлөгөө, мэдээлэл, Хамтын үйл ажиллагаа	жилдээ	ЦЕГ, Бүх шатны Засаг даргын Тамгын газар	ГБХЗХГ, ГХУСА33	Иргэдийн аюулгүй байдал хангагдаж, эрх зүйн туслалцааны хүртээмж сайжирсан байна.

1.1.4	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран сургалт, гэгээрүүлэх нөлөөллийн олон талт ажил, арга хэмжээг зохион байгуулах	Сургалт	жилдээ	ХЗҮХ, ЦЕГ	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, ГХУСАЗЗ	Нутаг дэвсгэрийн төр, захиргаа, хууль хяналтын байгууллагатай хамтран сургалт, зөвлөгөөнийг үе шаттай зохион байгуулсан байна.
1.1.5	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын чанар, үр нөлөөг сайжруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авах, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, сургалт зохион байгуулах	Сургалт зохион байгуулах	жилдээ	ЦЕГ, ШШГЕГ	Төрийн болон төрийн бус байгууллага,	Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйл эерэгээр өөрчлөгдсөн байна.
1.1.7	Зорилтот бүлэгт чиглэсэн сургалтын хөтөлбөр боловсруулж батлах, сургалтыг хөтөлбөрийн дагуу зохион байгуулах	Сургалтын хөтөлбөр, сургалт зохион байгуулах	жилдээ	ХЗҮХ	Төрийн болон төрийн бус байгууллага	Сургалтын агуулга чанартай болно.
1.1.8	Гэмт хэргийн гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, туслалцаа үзүүлэх эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх	Зөвлөгөө, мэдээлэл, үйл ажиллагаа	жилдээ	ЦЕГ	ГХУСАЗЗ	Эрх зүйн туслалцааны хүртээмж сайжирсан байна.
1.1.9	Гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалах үйл, ажиллагаанд оролцогч байгууллагын алба хаагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, мэргэшүүлэх, ур чадварыг нэмэгдүүлэх ажлын уялдааг сайжруулах	Сургалт, хэлэлцүүлэг хамтын ажиллагаа	жилдээ	ГХУСАЗЗ, ХЗҮХ, ЦЕГ, Бүх шатны Засаг даргын Тамгын газар	Шүүх, прокурор, Төрийн бус байгууллагууд	Хамтарсан сургалт, зөвлөгөөнийг үе шаттай зохион байгуулсан байна.
1.1.10	Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаа /Аюулгүй байдлын болон сэтгэл зүйн хамгаалалтын үйл ажиллагаа/, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах үйл ажиллагааны онцлог, ялгааг алба хаагчдад таниулах, мэдлэгийг дээшлүүлэх	Сургалт, хэлэлцүүлэг хамтын ажиллагаа	жилдээ	ГХУСАЗЗ, ХЗҮХ, ЦЕГ, Бүх шатны Засаг даргын Тамгын газар	Шүүх, прокурор, Төрийн бус байгууллагууд	Хамтарсан сургалт, зөвлөгөөнийг үе шаттай зохион байгуулсан байна.
1.1.11	Коронавируст /Covid-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах болон дархлаажуулалтын ажлыг дэмжих зорилгоор	Сургалт, хөдөлгөөн, хэлэлцүүлэг, конент		Үндэсний зөвлөл	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар,	Цар тахлаас урьдчилан сэргийлэх болон дархлаажуулалтын талаарх иргэдийн мэдлэг дээшилнэ

	иргэдийн зан үйлд нөлөөлөх, холбогдох хуулийг сурталчлах ажлыг үе шаттай зохион байгуулах		жилдээ		ГХУСАЗЗ	
Үйл ажиллагааны чиглэл 1.2. Хууль, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон захиргааны акт, хуулиар эрх олгосон этгээдийн гаргасан эрх зүйн үр дагавар бүхий шийдвэрийг бүрнээр нь болон хэсэгчлэн ангилсан байдлаар иргэдэд хүргэх эрх зүйн мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх						
1.2.1	Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем www.legalinfo.mn цахим хуудсыг шинэчлэн олон нийтэд хүргэх, сурталчлах	Шинэчлэгдсэн хувилбар	жилдээ	ХЗҮХ	ХЗДХЯ	Цахим хуудасны шинэ хувилбарыг олон нийтэд таниулсан байна.
1.2.2	Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем www.legalinfo.mn цахим хуудасны гар утсанд зориулсан хэрэглүүр /application/-ийг олон нийтэд хүргэх	Шинэ хэрэглүүр	жилдээ	ХЗҮХ	ХЗДХЯ	Шинэ аппликейшнийг хэрэглээнд нэвтрүүлсэн байна.
Үйл ажиллагааны чиглэл 1.3. Хууль тогтоомжийг бүхэлд нь болон тодорхой нэг хууль, захиргааны хэм хэмжээ тогтоосон акт, хуулиар эрх олгосон этгээдийн гаргасан эрх зүйн үр дагавар бүхий шийдвэр, тэдгээрийн тодорхой заалтыг олон нийтэд энгийн, ойлгомжтой хэлбэрээр тайлбарлан таниулах эрх зүйн сурталчилгааг тогтмол хийх						
1.3.1	Үндэсний зөвлөлийн гишүүн байгууллага тус бүр салбар чиглэл, чиг үүргийн хүрээнд иргэдийн эрх зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн ойлгомжтой, энгийн, хялбаршуулсан хэлбэрээр бэлтгэсэн сурталчилгааны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг тогтмол бэлтгэж нийтийн хүртээл болгох	Бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ	жилдээ	Үндэсний зөвлөл	Хэвлэл, мэдээллийн байгууллага	Үндэсний зөвлөлийн гишүүн байгууллага бүр тодорхой бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг нийтэд хүргэсэн байна.
1.3.2	Ерөнхий боловсролын сургуулиудын дэргэдэх "Өсвөрийн сэргийлэгч" бүлгэмтэй хамтран өсвөр насны хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрх зүйн боловсрол олгох ажлыг зохион байгуулж, мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллах	Сургалт, контент, тэмцээн	жилдээ	ЦЕГ	ГХУСАЗЗ, Насан туршийн боловсролын төв,	Хүүхдийн насны онцлог, хэрэгцээ, шаардлагад нийцүүлсэн байна.
1.3.3	Хүний эрхийн чиглэлээр Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенц, нийгмийн үнэт зүйлсийг сурталчлах сэдэвчилсэн аян, болзолт уралдаан зэрэг олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах	Сурталчилгааны аян, арга хэмжээ	жилдээ	ХЭҮК	ХЗДХЯ, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	Жилд 1 удаа зохион байгуулагдсан байна.

	Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын илтгэлүүд, болон Монгол Улсад өгсөн зөвлөмжийн эмхэтгэл бүхий “Хүний эрхийн олон улсын гэрээ ба Монгол Улс” хоёр боть номыг хэвлүүлэн, олон нийтийн хүртээл болгох;					
1.3.4	НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенц, түүний нэмэлт протокол, зөвлөмж болон Хүүхдийн эрх, Хүүхэд хамгааллын нас сэтгэхүйд тохируулан ойлгомжтой хэлбэрээр таниулах, сургалт зохион байгуулах	Сургалт	жилдээ	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	ГХУСАЗЗ	Иргэдийн эрх зүйн боловсрол дээшилсэн байна.
1.3.5.	“Эрх зүйн боловсролыг иргэн бүрд” хаштагтай аяныг нийгмийн сүлжээгээр ХЗДХЯ-ны харьяа болон бусад хуулийн байгууллагуудтай хамтран өрнүүлэх	Сурталчилгаа	жилдээ	ХЗҮХ, ХЗТТ, МХХ, МӨХ	ХЗДХЯ-ны харьяа агентлаг, байгууллагууд	Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлсэн байна.
Үйл ажиллагааны чиглэл 1.4. Иргэдэд эрх зүйн болон хүний эрхийн мэдлэг ойлголтыг түгээх, тэднийг чадавхижуулах, хүний эрхийн зөрчлийг ялгаж таних, эрх зүйн харилцаанд бие даан оролцох чадварыг эзэмшүүлэх мэдлэг, чадвар суулгах, эрх зүйн харилцаанд бие даан оролцох чадвар эзэмшүүлэх эрх зүйн шаталсан сургалтыг тогтмол явуулах						
1.4.1	Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн хүрээнд хүүхэд, залуучуудад хууль дээдлэх ёсыг төлөвшүүлэх, иргэний боловсрол, нийгмийн тухай мэдлэг олгоход мэргэжлийн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах	Хууль зүйн болон боловсролын байгууллагын хамтын ажиллагаа	жилдээ	БШУЯ,	ГБХЗХГ Үндэсний зөвлөл, Насан туршийн боловсролын үндэсний төв	Хичээлийн хөтөлбөр, багшлах боловсон хүчний хувьд тодорхой ахиц гарсан байна.
1.4.2	“Хүүхэд, гэр, бүл, залуучуудын эрх, үүрэг, оролцоо” амьдрах ухааны сургалтаар дамжуулан зорилтот гэр бүл, хүүхэд, залуучуудын хууль, эрх зүйн ойлголт, мэдлэгийг сайжруулах ажлыг зохион байгуулах	Төрийн болон ТББ-ын хамтын ажиллагаа	жилдээ	ГБХЗХГ	Төрийн болон төрийн бус байгууллага	2000 хүүхэд, 2000 гэр бүлийг хамруулсан байна
1.4.3	ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад хууль дээдлэх ёсыг төлөвшүүлэх, иргэний боловсрол, нийгмийн тухай мэдлэг, гэр бүлийн харилцаа, гэр бүлийн хүчирхийллийн талаар суурь	Сургалт	жилдээ	БШУЯ	ХЗҮХ, ГБХЗХГ Насан туршийн боловсролын үндэсний төв	Аймаг, нийслэлийн ЕБС-ийн ахлах ангийн 150 сурагчдад хөтөлбөрийн дагуу эрх зүйн мэдлэг

	ойлголтыг өгөх сургалт мэдээллийн нэг бүрчилсэн арга хэмжээг зохион байгуулах					олгох сургалтыг зохион байгуулсан байна.
1.4.4	Иргэдээс цагдаагийн алба хаагчтай харилцахдаа баримтлах хэм хэмжээ, эрх үүргийн талаар зөвлөгөө, мэдээлэл хүргэх	Зөвлөгөө, Мэдээлэл	жилдээ	ЦЕГ	-	Эрх зүйн мэдлэгийн түвшин сайжирсан байна
1.4.5	Дэлгэцийн донтолт, архи, тамхи, мансууруулах бодисын хор нөлөө, хүчирхийлэл, дарамт, шахалт, эрсдэлд өртөхөөс сэргийлэх талаар хүүхэд, өсвөр үеийнхэнд зориулсан хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах	Төрийн болон ТББ-ын хамтын ажиллагаа	жилдээ	ГБХЗХГ ЦЕГ БШУЯ	Төрийн болон Төрийн бус байгууллага	Хүүхэд өсвөр үеийнхэнд зориулсан хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулсан байна.
Үйл ажиллагааны чиглэл 1.5. Эрх зүйн анхан шатны зөвлөгөө өгөх, зорилтот бүлэгт өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх эрх зүйн туслалцааны чанар, хүртээмжийг сайжруулах						
1.5.1	Улсын өмгөөлөгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, эрх зүйн хөтчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллуулах сургалтыг тогтмол зохион байгуулах	Үйл ажиллагаа	жилдээ	ХЗТТ, МХХ	ХЗҮХ	Улсын өмгөөлөгчдийг сургалтад үе шаттай хамруулж, эдгээр сургалтыг хуульчийн үргэлжилсэн сургалтын кредит цагт тооцдог болсон байна.
1.5.2	Иргэдэд эрх зүйн анхан шатны зөвлөгөө өгөх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, иргэд шаардлагатай үедээ, оршин суугаа газраасаа хууль зүйн туслалцаа авах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх	Онлайн зөвлөгөө	жилдээ	ХЗҮХ, ХЗТТ, МХХ	НЗДТГ	Эрх зүйн туслалцааны хүртээмж нэмэгдсэн байна.
		Зөвлөгөө, мэдээлэл	жилдээ	МХХ, ХЗТТ	Нийслэл болон орон нутгийн Засаг даргын Тамгын газар	Алслагдсан сум, баг, дүүрэг, хороодод явуулын хуульчид ажиллаж хууль зүйн анхан шатны зөвлөгөө, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулсан байна.

1.5.3	Өмгөөлөгчид, хуулийн фирмүүд төлбөрийн чадваргүй, эмзэг бүлгийн иргэдэд үнэ төлбөргүй болон бага үнээр эрх зүйн туслалцаа үзүүлдэг байх, хууль зүйн туслалцааны төв, түүний салбар нэгжтэй хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх	Хамтын ажиллагаа	жилдээ	МХХ, ХЗТТ	ХЗҮХ	Үнэ төлбөргүй болон бага үнээр хууль зүйн туслалцаа авах боломж нэмэгдсэн байна.
1.5.4	"Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн 1800-1202 тусгай дугаар" болон "Хууль Зүйн Луужин 1" фэйсбүүк цахим хуудсаар дамжуулан хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл хүргэх ажлын хүртээмжийг нэмэгдүүлэх	Зөвлөгөө, мэдээлэл	жилдээ	ХЗҮХ	ХЗДХЯ	Эрх зүйн туслалцааны хүртээмж сайжирсан байна.
Үйл ажиллагааны чиглэл 1.6. Иргэдэд тулгарч буй хууль зүйн асуудал, эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, хууль зүйн анхан шатны үйлчилгээний бодит хэрэгцээ шаардлагыг тогтоож, шийдвэрлэх бодлогын шийдлийг тодорхойлоход туслах эрх зүйн судалгаа хийж, үр дүнг тооцдог болох						
1.6.1	Цахим хэлбэрээр тодорхой сэдвийн хүрээнд судлаач нарыг оролцуулан хэлэлцүүлэг өрнүүлэх	Хэлэлцүүлэг	жилдээ	ХЗҮХ	-	Оролцоог хангасан байна.
1.6.2	Хөтөлбөрийн II үе шатны (2018-2020) хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийх	Тайлан, зөвлөмж	жилдээ	ХЗДХЯ	ХЗҮХ	Судалгаанд суурилсан, хэрэгцээ шаардлагад нийцсэн, оролцоог хангасан байна.
Зорилт 2: Бүх нийтийн эрх зүйн болон хүний эрхийн боловсролыг дээшлүүлэхэд шаардлагатай нөөцийг бүрдүүлж, тогтсон сувгуудыг бий болгон, тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг бүх нийтэд хүргэнэ.						
Үйл ажиллагааны чиглэл 2.1. Хууль зүйн анхан шатны туслалцаа үзүүлэх эрх зүйн хөтчийн тогтолцоо бий болгох						
2.1.1	Эрх зүйн хөтөч бэлтгэх сургалтыг хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу нийслэл, орон нутагт зохион байгуулах /УБ хот, Ховд, Баян-Өлгий, Говь-Алтай аймагт эрх зүйн хөтөч бэлтгэх сургалт/	Эрх зүйн хөтөч	жилдээ	ХЗҮХ, Нийслэлийн ЗДТГ,	ХЗДХЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ, Олон улсын болон ТББ	Сум, хороо бүрд 1-ээс доошгүй эрх зүйн хөтөчтэй болсон байна.
2.1.2	Бэлтгэгдсэн эрх зүйн хөтөч нарыг ном, гарын авлага, хэрэглэгдэхүүнээр хангах	Шаардлагатай хэрэглэгдэхүүнээр хангах	жилдээ	ХЗҮХ	Аймаг, нийслэлийн ЗДТГ	Нэг эрх зүйн хөтчийг 2-с доошгүй ном, гарын авлагаар хангасан байна.

2.1.3	Эрх зүйн хөтчийн үйл ажиллагааг бэхжүүлж, орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах	Хамтын ажиллагаа	жилдээ	ХЗДХЯ Үндэсний зөвлөл	Аймаг, нийслэлийн ЗДТГ	Хамтын ажиллагаа сайжирч, тайланг тогтмол хугацаанд авсан байна.
2.1.4	Эрх зүйн хөтчийн давтан сургалт зохион байгуулах (7 хүртэлх аймагт)	Сургалт	жилдээ	ХЗҮХ	ХЗДХЯ	7 хүртэлх аймагт сургалтыг зохион байгуулж 200-аас доошгүй эрх зүйн хөтөч сургалтад хамруулсан байна.
2.1.5	Тусгай хэрэгцээт иргэдэд эрх зүйн мэдлэг олгох мэргэжлийн хөтөч бэлтгэх	Сургалт	жилдээ	ХБИНХ	ХЗҮХ	Эрх зүйн туслалцааны хүртээмж сайжирсан байна.
2.1.6	Нийгмийн харилцааны тодорхой салбараар дагнасан эрх зүйн хөтөч нар бэлтгэх ажлыг зохион байгуулах	Сургалт, хамтын ажиллагаа	жилдээ	ХЗҮХ, Үндэсний зөвлөл	НҮТББ ТББ	Мэргэжсэн эрх зүйн хөтөч нарыг бэлтгэж эхэлсэн байна.
2.1.7	Эрх зүйн хөтөч нарын нэгдсэн групп үүсгэх замаар нэгдсэн удирдамж, арга зүйгээр хангаж ажиллах, эрх зүйн мэдээлэл, зөвлөгөө авах хэрэгцээ шаардлагыг тодорхойлох	Хамтын ажиллагаа	жилдээ	ХЗҮХ	-	Эрх зүйн хөтөч нараас иргэдэд үзүүлэх зөвлөгөө мэдээллийн чанарт ахиц гарна.
Үйл ажиллагааны чиглэл 2.2. Эрх зүйн хөтчийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх						
2.2.1	Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн www.e-khutuch.mn цахим хуудасны найдвартай хэвийн ажиллагааг хангах, баяжилт, хөгжүүлэлтийг тогтмол хийж, цахим хуудсыг нийтэд сурталчлах ажлыг тогтмол зохион байгуулах	Улсын төсөв	жилдээ	ХЗҮХ	ХЗДХЯ	e-khutuch.mn цахим хуудасны үйл ажиллагаа тогтворжсон байна.
2.2.2	Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн www.e-khutuch.mn цахим хуудсанд эрх зүйн сургалт, сурталчилгааны контент, богино хэмжээний шторк байршуулах	Цахим контент, мэдээлэл	жилдээ	ХЗҮХ	Олон улсын байгууллага, ТББ	Подкаст нэвтрүүлэг, постер, шторк хэлбэрээр хууль зүйн мэдээлэл, зөвлөгөө нийтэд түгээсэн байна.
2.2.3	Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн www.e-khutuch.mn цахим хуудсаар мэдээллийг шуурхай авах, өөрийн оршин суугаа газарт ажиллаж байгаа эрх зүйн хөтөч нарын мэдээллийг цаасан болон бусад хэлбэрээр авах, ашиглах боломжийг бүрдүүлсэн “Эрх зүйн	“Эрх зүйн хөтчийн мэдээллийн булан”		ХЗҮХ	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	10-аас доошгүй аймагт “Эрх зүйн хөтчийн мэдээллийн булан”-г ажиллуулдаг болсон байна.

	хөтчийн мэдээллийн булан"-г аймаг, нийслэлийн төрийн үйлчилгээний нэгдсэн төвүүдэд тохижуулж, ажиллуулах		жилдээ			
Үйл ажиллагааны чиглэл 2.3. Эрх зүйн мэдээлэл, сургалт сурталчилгаа, судалгаанд мэдээллийн технологийг ашиглах						
2.3.1	Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн зориулалтаар аудио болон подкаст нэвтрүүлэг зэрэг шинэлэг контентийг бэлтгэх, эсхүл бэлтгэсэн контентийг олон нийтийн сүлжээгээр дамжуулан тогтмол, давтамжтайгаар нийтийн хүртээл болгох	Мэдээлэл, сурталчилгаа	жилдээ	ХЗҮХ	Үндэсний зөвлөл, ХЗДХЯ, ТББ	Иргэдэд ойлгомжтой хууль зүйн мэдээ, мэдээллийг Үндэсний зөвлөлийн гишүүн бүр тус тусын салбар, чиглэлээр олон нийтийн сүлжээгээр дамжуулан нийтийн хүртээл болгосон байна.
2.3.2	"Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн 1800-1202 тусгай дугаар"-ын утасны хэвийн ажиллагааг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлэх	Үйлчилгээ	жилдээ	ХЗҮХ	ХЗДХЯ	Хэвийн ажиллаж зөвлөгөө, мэдээлэл авсан иргэдийн тоо өссөн байна.
Үйл ажиллагааны чиглэл 2.4. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем / www.legalinfo.mn /-ийн мэдээллийн санг өргөтгөн хөгжүүлэх						
2.4.1	Эрх зүйн мэдээллийн www.legalinfo.mn нэгдсэн цахим системийн програм хангамжийн шинэчлэл болон хөгжүүлэлтийг олон нийтэд сурталчлах	Шинэчлэгдсэн програм хангамж бүхий эрх зүйн нэгдсэн систем	жилдээ	ХЗҮХ	ХЗДХЯ	Мэдээллийн сангийн хүчин чадал нэмэгдэж, хэрэглэгчийн тоо өссөн байна.
2.4.2	Эрх зүйн мэдээллийн www.legalinfo.mn нэгдсэн цахим системийг олон нийт, хуульчдын оролцоотойгоор хөгжүүлэх, засварлах арга хэмжээг авч ажиллах	Хамтын ажиллагаа	жилдээ	ХЗҮХ	ХЗДХЯ	Цахим мэдээллийн сангийн үйлчилгээний чанар хүртээмж дээшилнэ.
Үйл ажиллагааны чиглэл 2.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдүүдэд эрх зүйн мэдээлэл, зөвлөгөө, туслалцаа үзүүлэх хүний нөөц /дохионы хэлний хэлмэрч, сэтгэл зүйч/-ийг бэлтгэх						
2.5.1	Эрх зүйн хөтөч, өмгөөлөгчийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон бусад зорилтот бүлэгт хууль зүйн туслалцаа үзүүлэх, сургалт сурталчилгаа явуулахад шаардлагатай сэтгэл зүйн анхан шатны сургалтад хамруулах	Сургалт	жилдээ	ХЗҮХ, ХЗТТ МХХ, ХБИНХ	ХЗДХЯ, ЭМЯ ХБХХЕГ, ТББ	50-иас доошгүй хүн сургалтад хамрагдсан байна.

Зорилт 3: Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд бүх талын идэвхтэй оролцоог хангаж, тэдний үйл ажиллагааг уялдуулна.						
Үйл ажиллагааны чиглэл 3.1. Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх						
3.1.1	Бүх нийтийн эрх зүйн боловсролын Үндэсний Зөвлөлийг хуралдуулах	Хурал, хурлын тэмдэглэл, шийдвэр	жилдээ	ХЗҮХ	ХЗДХЯ	Жилд 1-ээс доошгүй удаа хурлыг зохион байгуулж, гишүүдийн оролцоог хангасан байна.
Үйл ажиллагааны чиглэл 3.2. Эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгаанд орон нутгийн засаг захиргааны байгууллагууд болон Хууль зүйн туслалцааны төвийн орон нутаг дахь салбарын оролцоог нэмэгдүүлэх						
3.2.1	Бүх шатны Засаг даргын Тамгын газраас өөрийн аймаг, сум, дүүргийн төрийн үйлчилгээний болон бусад мэдээллийг тогтмол www.e-khutuch.mn цахим хуудаст оруулж баяжуулах	Хамтын ажиллагаа	жилдээ	ХЗҮХ	Бүх шатны Засаг даргын Тамгын газар	ХЗҮХ болон бүх шатны Засаг даргын Тамгын газраас холбогдох мэдээллийг цахим хуудаст оруулж баяжуулсан байна.
3.2.2	Эрх зүйн хөтчийн үйл ажиллагаанд улсын өмгөөлөгч, бусад өмгөөлөгчийн зүгээс дэмжлэг үзүүлж хамтран ажиллах	Хамтын ажиллагаа	жилдээ	ХЗТТ, МХХ	ХЗДХЯ, Аймаг, сумын Засаг даргын Тамгын газар	Эрх зүйн хөтчид дэмжлэг үзүүлж хамтран ажилласан байна.
Үйл ажиллагааны чиглэл 3.3. Эрх зүйн мэргэжлээр сургалт явуулдаг их, дээд сургуулиуд болон ТББ-ын дэргэдэх хууль зүйн клиник төвөөс иргэдэд эрх зүйн болон хүний эрхийн анхан шатны зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг нь тогтмолжуулах, чадавхжуулах, эрх зүйч мэргэжлээр сурч буй оюутнуудын эрх зүйн хөтчөөр ажиллах сайн дурын үйл ажиллагааг бүх талаар дэмжих						
3.3.1	Хууль зүйн их, дээд сургууль, ТББ-уудтай хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах	Хамтын ажиллагаа	жилдээ	ХЗҮХ	Хууль зүйн их, дээд сургууль, ТББ-ууд	Хамтран ажиллаж, бодит үр дүн гаргасан байна.
Үйл ажиллагааны чиглэл 3.4. Эрх зүйн сургалт, сурталчилгаа, судалгааны ажилд төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоог хангах						
3.4.1	Эрх зүйн сургалт, сурталчилгаа, судалгааны ажлын төлөвлөгөөтэй уялдуулан ТББ, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах гэрээ, санамж бичиг байгуулах	Хамтран ажиллах гэрээ, санамж бичиг	жилдээ	ХЗҮХ	ТББ, ААНБ	Эрх зүйн сургалт, сурталчилгаа, судалгааг тодорхой шалгуур хангаж, мэргэшсэн баг гүйцэтгэдэг туршлага өргөжсөн байна.

Үйл ажиллагааны чиглэл 3.5. Хэвлэл мэдээллийн байгууллага, үүрэн холбооны аж ахуйн нэгжийн үүрэг хариуцлагыг өндөржүүлж, ТББ, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагыг эрх зүйн болон хүний эрхийн мэдээлэл, сурталчилгааны ажилд оролцохыг бүх талаар дэмжих

3.5.1	Хэвлэл, мэдээллийн байгууллага, үүрэн холбооны оператор компани болон бусад хувийн хэвшлийн байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд нийгмийн хариуцлагын хүрээнд эрх зүйн мэдээлэл, сурталчилгааны ажилд оролцохыг уриалах, хамтын ажиллагааны санамж бичгийг боловсруулж байгуулах	Уриалга, санамж бичиг	жилдээ	Үндэсний зөвлөл	Хэвлэл мэдээлэл, үүрэн холбооны оператор компани бусад хувийн хэвшлийн байгууллага	Уриалга гаргаж, санамж бичиг байгуулан хамтран ажилласан байна.
3.5.2	МҮОНРТ-ийн “Монголын мэдээ” телевизийн “Эрх зүйн хөтөч” нэвтрүүлэгтэй хамтран ажиллах	Нэвтрүүлэг	жилдээ	Үндэсний зөвлөл	МҮОНРТ	Тогтмол, давтамжтайгаар олон нийтэд хүргэсэн байна.
3.5.3	Эрх зүйн сургалт сурталчилгаанд ашиглах аудио, видео контент хөгжүүлж, хөдөө орон нутагт түгээх эрх бүхий телевизүүдтэй хуваалцаж ажиллах	Арга хэмжээ	жилдээ	ХЗҮХ, ХЭҮК ЦЕГ, Орон нутгийн хэвлэл, мэдээллийн холбоо	ХЗДХЯ	Олон нийтэд хүргэсэн байна.

Үйл ажиллагааны чиглэл 3.6. Эрх зүйн мэдлэг, боловсролоо дээшлүүлэх, эрх зүйн тодорхой түвшний эрх зүйн мэдлэг эзэмшсэн хамт олон болж, үүнийгээ баталгаажуулах чиглэлээр санал, санаачилга өрнүүлэх арга хэмжээг зохион байгуулах

3.6.1	Иргэн бүрийн мэдвэл зохих хууль тогтоомж, эрх зүйн актын талаар хялбаршуулсан нугалбар хуудас бэлтгэж нийтэд тогтмол хүргэх	Арга хэмжээ	жилдээ	Үндэсний зөвлөл		Үндэсний зөвлөлийн гишүүн байгууллага бүр тус тусын салбар, чиглэлээр бэлтгэж нийтийн хүртээл болгосон байна.
-------	---	-------------	--------	-----------------	--	---

Үйл ажиллагааны чиглэл 3.7. Төрийн болон төрийн бус байгууллагууд өөрийн үйл ажиллагааны чиглэлээр мэргэшсэн эрх зүйн хөтөч ажиллуулах:

3.7.1	Төрийн болон төрийн бус байгууллагууд өөрийн үйл ажиллагааны хүрээнд эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа хариуцсан ажилтныг эрх зүйн хөтчийн сургалтад хамруулан бэлтгэх	Арга хэмжээ	жилдээ	Үндэсний зөвлөл	Төрийн болон ТББ-ууд	Төрийн болон төрийн бус байгууллагууд салбарын эрх зүйн хөтөчтэй болсон байна.
-------	--	-------------	--------	-----------------	----------------------	--

3.7.2	Төрийн байгууллагууд хөдөө орон нутагт ажиллаж байгаа эрх зүйн хөтчийг богино хугацааны сургалтад хамруулах замаар салбарын хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр мэргэшүүлэх	Арга хэмжээ	жилдээ	ХЗДХЯ, Үндэсний зөвлөл	ХНХЯ, ЭМЯ, Татварын ерөнхий газар	Төрийн болон төрийн бус байгууллагууд салбарын эрх зүйн хөтөчтэй болсон байна.
-------	--	-------------	--------	---------------------------	--------------------------------------	--

Товчилсон үгийн тайлал:

ХЗДХЯ-Хууль зүй, дотоод хэргийн яам

ХЗҮХ-Хууль зүйн үндэсний хүрээлэн

БОАЖЯ-Байгаль орчин, аялал жуулчлалын яам

БШУЯ-Боловсрол, соёл, шинжлэх ухаан,

ХНХЯ-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

ЭМЯ-Эрүүл мэндийн яам

ГБХЗХГ-Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар

НЗДТГ-Нийслэлийн Засаг даргын Тамгын газар

ЦЕГ-Цагдаагийн ерөнхий газар

ХЭҮК-Хүний Эрхийн Үндэсний Комисс

ХЗТТ-Хууль зүйн туслалцааны төв

МҮОНРТ-Монголын үндэсний олон нийтийн радио телевиз

МХХ-Монголын хуульчдын холбоо

ОНХМХ-Орон нутгийн хэвлэл мэдээллийн холбоо

ХБИНХ-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбоо

ГХУСАЗЗ-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл

ТББ-Төрийн бус байгууллага

ХБХХЕГ-Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар